

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАРЪЯАНЫ БҮХ АГЕНТЛАГУУД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

2023.11.15

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль								
1	1	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	УБЕГ-аас “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлан, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гарган хүргүүлэн ажиллаж байна. Улсын бүртгэлийн байгууллагын “Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд “Байгууллагын онцлогт тохируулан, Төрийн албаны тухай хууль болонхолбогдох бусад хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөтэй нийцүүлэн тодорхойлж, албан хаагчдын мэдлэг ур чадварыг байгууллагын үнэт зүйлс болгон төлөвшүүлэх” зорилгоор сургалтуудыг	100		

					зохион байгуулан ажиллаж байна.			
2	2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах.	Хэлтсийн албан ёсны цахим хуудас <a href="https://govisumber.burtgel.gov.mn/">https://govisumber.burtgel.gov.mn/</a> сайтад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан нээлттэй мэдээллийг байршуулж, олон нийтэд ил тод мэдээллэж ажиллав. Мөн аймгаас дээрх үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалт хийгдсэн болно. Байгууллагын эрхэм зорилгыг “Иргэдэд үйлчлэх танхим”-д, стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг сайтад нийтэд ил тод байршуулав.	100		
	3		8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг цахим хуудсанд байршуулах.	Байгууллагын сайтад чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг зэргийг нийтэд ил тод байршуулав.	100		
	4		8.2.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Хэлтсийн мэдээллийн самбар, байгууллагын сайтад үйл ажиллагааны тайлан, аудитын дүгнэлтийг ил тод байршуулсан. Тайлангийн хугацаанд акт, албан шаардлага аваагүй болно.	100		
	5		8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;		Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.			
	6		8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн	Тус хэлтэст хамааралгүй			



			тайлан цахим хуудаст байршуулах			
7		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Байгууллагын цахим хуудсанд бүртгэлийн чиглэлээр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмыг бүрэн байршуулсан.	100	
8		8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг цахим хуудаст байршуулах.	Албан тушаалын тодорхойлолт УБЕГ-аас батлагдан ирсэн ба тодорхойлолтуудыг албаны цахим хаягт байршуулсан. Албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг цахим хуудаст байршуулсан.	100	
9		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг хугацаанд нь гарган мэдээллийн самбар болон цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулах	2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар нийт 26 өргөдлийг зохих журмын дагуу бүртгэн хүлээн авсан. Үүний 8 өргөдөл нь албан хаагчдаас, 18 өргөдөл нь иргэдээс ирсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал бүр холбогдох газарт хүргүүлж, ирсэн өргөдөл, гомдлыг EDOC системд тухай бүр бүртгэж, хяналт тавьж ажиллав. 26 өргөдлийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг мэдээллийн самбар болон цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулан ажиллаж байна.	100	
10		8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Аймгийн статистик мэдээллийг цахим хуудсанд байршуулах.	Байгууллагын сарын тоон мэдээ, тайланг цахим хуудсанд тухай бүрт нь байршуулсан.	100	
12		8.3.1. ажлын байрны сул орон тооны	Ажлын байрны сул орон	Ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын цахим хаягт 3 удаа	100	

		талаарх мэдээлэл;	тооны судалгааг тухай бүр шинэчилж цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулах	байршуулсан. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт улирал бүр сул ажлын байр, орон тоог гарган өгч хамтран ажиллаж байна.			
13		8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулах	Улсын бүртгэлийн ерөнхий газарт хийгддэг. Тус аймгийн сул орон тоонд 2 удаагийн сонгон шалгаруулалт явагдаж 2 иргэн оролцон тэнцэж, албан тушаалд томилогдсон.	100		
14		8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрмийг мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулах	Байгууллагын цахим хаягт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байршуулсан.	100		
15		8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	“Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг 4 жилээр төлөвлөн батлуулж цахим хуудсанд байршуулах	Байгууллагын цахим хаягт “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”, төлөвлөгөөг байршуулсан.	100		
16		8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Аймгийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг тогтмол шинэчлэх	Аймгийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.	100		
17		8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам болон албан хаагчдыг үнэлсэн үнэлгээг иргэдэд ил тод байдлаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Байгууллагын цахим хаягт Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг байршуулсан	100		
18		8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл,	Өмнөх оны төсвийн	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн	100		

		тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг нийтэд мэдээлэх	жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг нийтэд мэдээлэх байгууллагын цахим хаягт байршуулсан.			
19		8.4.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас, шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	2022 оны жилийн эцэс болон 2023 оны санхүүгийн тайланг хийж холбогдох сайт, харъяа холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлж байгууллагын цахим хаягт тухай бүр байршуулсан.	100		
20		8.4.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	2022 оны Санхүүгийн Аудитаар зөрчилгүй дүгнэгдсэн тайланг байгууллагын цахим хаягт байршуулсан.	100		
21		8.4.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоосон шийдвэрийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулах.	Улсын бүртгэлийн ерөнхий хууль 2017 онд шинэчлэгдэн батлагдаж 2022 оны 7 сараас түүнтэй холбоотой дүрэм журам мөрдөгдөж байна. Байгууллагын цахим хаягт хууль дүрэм, төлбөр хураамжийн мэдээллийг байршуулсан.	100		
22		8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг шилэн дансанд байршуулах	Тайлант оны нийт 377.752.600 төгрөгийн санхүүжилтээс 11-р сарын байдлаар 377.752.600 төгрөгний санхүүжилт хийгдэж, 33366496636 төгрөг зарцуулаад байна. Өглөг урсгал засварын зардал болон бичиг хэргийн материалд үүссэн байна. Шилэн дансанд мэдээллийг байршуулсан.	100		
23		8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр,	Шилэн дансанд 5.0 сая гэхээгүй аж ахуй нэгж рүү шилжүүлсэн төлбөрийн баримтуудыг PDF оруулж хийдэг.	100		

			санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх				
24		8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Шилэн дансанд санхүүжилт болон орлогын мөнгөн гүйлгээг тогтмол хийж хэвшсэн.	100		
25		8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Аймгийн төсөв баталсан болон төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоолуудыг нийтэд мэдээлэх	Тухайн сард гарсан тушаал шийдвэрийг шилэн дансанд байршуулдаг.	100		
26		8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансанд мэдээллийг бүрэн оруулж, нийтэд мэдээлэх	Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 онд нийт 175 мэдээ оруулахаас 11-р сарын байдлаар шилэн дансанд 134 мэдээ мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хожимдуулж мэдээлэл байхгүй.	100		
27		8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Төрийн аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт цахим хуудсанд байршуулах	2023 оны 3-р улирлын байдлаар “Баталгаат тооцоолол” аудитад баримтаа өгөөд байна. Шалгалтын дүн ирээгүй.	50		
28		8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг цахим хуудсанд	Тус хэлтэс бие дааж төсөл хөтөлбөрт хамрагдаагүй УБЕГазар төсөл хөтөлбөрт хамрагддаг.	100		

				байршуулах.				
	29		8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах.	Шилэн дансанд мэдээлэл байршуулахаас гадна шилэн данс самбарт мэдээллийг байршуулж хэвшсэн.	100		
	30		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Мэдээллийг тогтмол байршуулах	Хэрэгжээгүй	0		
3	102	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257	2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.		Угийн бичиг хөтлөх талаар сургалт авах 2023.04.19-ний №212 албан бичгийг аймгийн Боржигин өв музейд хүргүүлэн, 04 дүгээр сарын 25-ны өдөр алба хаагчдад аймгийн Боржигин өв музейн мэргэжилтэн М.Уянга “Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалт” –ыг зохион байгуусан. <b>Хүрсэн үр дүн:</b> 2 албан хаагч угийн бичиг хөтлөж байна.	100		
<b>Ерөнхийлөгчийн зарлиг</b>								
4	31	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	- Бүх шатны байгууллагын гадна, дотно хаягийг хос бичгээр бичих ажлыг зохион байгуулах - Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжих	Хэлтсийн гадна хаягийг монгол бичиг крилл үсгээр хослуулан шинэчилсэн. Иргэний улсын бүртгэлийн гэрчилгээнд мэдээллийг монгол бичгээр бичдэг болсон бөгөөд иргэдэд монгол бичгийг түгээн дэлгэрүүлж ажиллаж байна. Монгол бичгийн хэвлэмэл хуудсын эхийг бэлтгүүлэн Архивын ерөнхий газарт захиалж 57000 төгрөгөөр 400 ш хэвлэмэл хуудсыг хэвлүүлэн авсан. Монгол бичиг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”-ийг хариуцсан ажилтнаар архивч Ц.Дүгэрсүрэнг томилов. Албан	100		

					<p>хаагчдад Монгол бичгийн анхан шатны 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Хэлний бодлогын үндэсний зөвлөл, АЗДТГ-ын архивын тасагтай хамтран 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлага MNS:6395:2022 стандартыг хэрэгжүүлэх” сургалтад 2 албан хаагч, 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг дээшлүүлэх” сургалтад 3 албан хаагч тус тус хамрагдсан байна.</p>			
5	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	<p>1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах</p>		<p>Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдаж буй Говьсүмбэр аймгийн 2023 оны хавар, намрын бүх нийтээр мод тарих арга хэмжээнд тус хэлтсийн давхардсан тоогоор 23 албан хаагч, хавар 75 ширхэг, намар 20 ширхэг, нийт 190,000 төрөгийн 95 ширхэг хайлаас модыг Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд тарьлаа. Байгууллагын хариуцсан газар болох аймгийн үдэлтийн хаалганы дэргэдэх талбайн хогийг 2 удаа цэвэрлэж, цэнэг усалгааг Сум дундын ойн ангиас гаргасан усалгааны хуваарийн дагуу 4 удаа хийгээд байна.</p>	 	100		



					Байгууллагын гадна талын өнгө үзэмжийг нэмэгдүүлж, цэцгийн үр суулгаж, ногоон байгууламжид байнгын усалгааг хийж байна.				
6		Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.		2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн морин цагт Эзэн Богд Чингис хааны эш хөргийг иргэдэд үйлчлэх үйлчилгээний зааланд хүндэтгэн залсан.  Тус хэлтсийн 3 өрөөнд /дарга, тасгийн дарга, иргэдэд үйлчлэх үйлчилгээний заал/ Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залаад байна.	100			
<b>ЗГ-ЫН ТОГТООЛ</b>									
7	39	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_203	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Төрийн албан хаагчдыг богино хугацааны сургалтад хамруулах	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн дотоод хөргийн яам, Удирдлагын академитай хамтран “Алсын хараа-2050” Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” танхимын сургалтад 2 албан хаагч, онлайн сургалтад 3 албан хаагч хамрагдан сертификат авсан.	100			

	40		<p>3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг “Удирдлагын академи”-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.</p>	<p>Төрийн албан хаагчдыг богино болон дунд хугацааны сургалтад Удирдлагын академиас ирүүлсэн квотын дагуу хамаруулах</p>	<p>Аймгийн ЗДТГ, Удирдлагын академитай хамтран 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан “Шилжилт хөдөлгөөний бодлого зохицуулалт” сургалтад 3 албан хаагч, АЗДТГ, Удирдлагын академитай хамтран 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Хөдөлмөрийн тухай хуулийн мэдлэг олгох сургалт” сэдэвт 3 цагийн сургалтад 2 албан хаагч, АЗДТГ-аас 10 дугаар сарын 20-ны өдөр Боржигин чуулгад зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын сургалта”-д 7 албан хаагч тус тус хамрагдсан.</p>	100		
8	41	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203</p>	<p>1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай:  1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;  1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;  1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна. Тодруулбал бичиг хэргийн зардлыг хэмнэх үүднээс албан хаагчдад бичгийн цаасыг 1 сард 1 удаа өгч ажиллаж байна.</p>	100		

			ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.				
9	42	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн	Байгууллагуудын гадна болон дотор хаягжилтийг 85 хувьд хүргэх, төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ	Хэлтсийн гадна хаягийг монгол бичиг крилл үсгээр хослуулан шинэчилсэн. Иргэний улсын бүртгэлийн гэрчилгээнд мэдээллийг монгол бичгээр бичдэг болсон бөгөөд иргэдэд монгол бичгийг түгээн дэлгэрүүлж ажиллаж байна. Монгол бичгийн хэвлэмэл хуудсын эхийг бэлтгүүлэн Архивын ерөнхий газарт захиалж 57000 төгрөгөөр 400 ш хэвлэмэл хуудсыг хэвлүүлэн авсан. Монгол бичиг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”-ийг хариуцсан ажилтнаар архивч Ц.Дүгэрсүрэнг томилов. Албан хаагчдад Монгол бичгийн анхан шатны 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Хэлний бодлогын үндэсний зөвлөл, АЗДТГ-ын архивын тасагтай хамтран 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлага MNS:6395:2022 стандартыг хэрэгжүүлэх” сургалтад 2 албан хаагч, 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын	100	

			байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.		үндэсний бичгийн мэдлэг дээшлүүлэх” сургалтад 3 албан хаагч тус тус хамрагдсан байна.			
10	45	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./		Улсын бүртгэлийн ерөнхий газарт хамааралтай.  Иргэний баримт бичиг, шилжилт хөдөлгөөний хаягийн бүртгэлд үзлэг хийх тухай 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/61 тоот аймгийн засаг даргын захирамж гарсан. Захирамжийн дагуу ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тус хэлтсээс 2023 оны 04, 09 дүгээр саруудад давхардсан тоогоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 97 аж ахуйн нэгж болон төрийн байгууллагад албан хаагчдынхаа хаягийн судалгаа ирүүлэх мөн өөр аймгийн харьяалалтай иргэдийг шилжүүлэн ирүүлэх тухай тоот хүргүүлсэн. Энэ оны 10 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 21 байгууллагаас хариу ирүүлсэн. Үүнээс 21 байгууллагын 86 иргэн өөр аймгийн харьяатай байх тул буцаан тоот хүргүүлээд байна. Өссөн дүнгээр УБ хотоос 129 / өөр аймгаас 289 нийт 418 иргэн шилжин ирсэн байна. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэлсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн сул орон тоонд Дундговь аймгаас Р.Мөнхбат, мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн сул орон тоонд Улаанбаатар хотоос З.Чагцалмаа, Баянтал сумын улсын бүртгэгчийн сул орон тоонд Дундговь	100		

					аймгаас Б.Цэрэнням, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн сул орон тоонд Дундговь аймгаас Ж.Азжая нарыг хуулийн дагуу тус тус шилжүүлэн ажиллуулах ажлыг зохион байгуулав.			
11	47	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2022-12-28 Дугаар 2022_488	5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.		Монгол Улсын засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоол, УБЕГ-ын 2023 оны “Гэрээт албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай” Б/98 тушаал, “Хоол, унааны нөхөн төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” Б/101 дүгээр тушаал, УБЕГ-ын 501, 502 тушаалаар батлагдсан төсөвтөө багтаан албан хаагчдаа цалинжуулж байна. Одоогоор цалин санд өглөг , авлага үүсээгүй байна.	100		
<b>ЗГ-ын хуралдааны тэмдэглэл</b>								
12	50	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлэх И-Монголиа системд орон нутгаас үзүүлж буй төрийн үйлчилгээнүүдийг холбох	Тайлангийн хугацаанд /2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар/ Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим <a href="mailto:govisumber@burtgel.gov.mn">/govisumber@burtgel.gov.mn</a> , <a href="mailto:21aimag@burtgel.gov.mn">21aimag@burtgel.gov.mn</a> ,/ хаягаар 156 дотоод албан бичиг, EDOC, ERP системээр 397, бусад байгууллагаас цаасаар 583, нийт 1136 албан бичиг ирснийг бүртгэлд авч, 358 албан бичигт хариу хүргүүлэв. Хугацаа болоогүй 5 бичиг хяналтад байна. Тус хэлтсээс 497 албан бичгийг явуулж, 8 албан бичгийн хариуг авсан байна.	100		
13	51	2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23	X.5. . 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл,	1. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг олон сувгаар хүлээн авах 2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт иргэн, аж ахуйн	Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд тус Улсын бүртгэлийн хэлтэстэй холбогдуулан хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй байна.	100		

		Дугаар 2022_12	гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлүүлж, нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын тайланг нэгтгэн Засгийн газрын хэрэг Эрхлэх газарт хүргүүлэх.	Үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилгоор хэлтсийн ажлын байр, үйлчилгээний танхим болон 3 суманд мэдээллийн самбар, саналын хайрцаг ажиллуулж, 70541890, 70543056 дугаарын утсуудаар мэдээлэл, зөвлөгөөг тогтмол өгч байна. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 894 иргэн утсаар зөвлөгөө мэдээлэл авсан бөгөөд иргэдээс ямар нэгэн гомдол гаргаагүй байна.  2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар нийт 26 өргөдлийг зохих журмын дагуу бүртгэн хүлээн авсан. Үүний 8 өргөдөл нь албан хаагчдаас, 18 өргөдөл нь иргэдээс ирсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал бүр холбогдох газарт хүргүүлж, ирсэн өргөдөл, гомдлыг EDOC системд тухай бүр бүртгэж, хяналт тавьж ажиллав. 26 өргөдлийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна.			
14	52	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын		Тайлангийн хугацаанд /2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар/ Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим <a href="mailto:/govisumber@burtgel.gov.mn">/govisumber@burtgel.gov.mn</a> , <a href="mailto:21aimag@burtgel.gov.mn">21aimag@burtgel.gov.mn</a> / хаягаар 156 дотоод албан бичиг, EDOC, ERP системээр 397 албан бичиг ирснийг бүртгэлд авч, 210 албан бичигт хариу хүргүүлэв. Тус хэлтсээс 497 албан бичгийг явуулсан ба үүний 324 бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан албан бичиг солилцооны дундын системийг	100		

			удирдлагад үүрэг болгов;		ашиглан илгээсэн байна.  И-Монгол Академи УТҮГ болон Архивын ерөнхий газартай хамтран 05 дугаар сарын 24-ны өдөр “Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах” 3 цагийн сургалтад 2 албан хаагч, 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан “E-DOC системийг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглах, албан бичиг боловсруулах, хянах илгэх байгууллага сонгох” сургалтад 2 албан хаагч, 10 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт” сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан байна.			
15	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн			Тус хэлтэс албан хэрэг хөтлөлтийн EDOC систем ашиглаж байгаа бөгөөд 324 бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан албан бичиг солилцооны дундын системийг ашиглан илгээсэн байна.	100		

			удирдлагад үүрэг болгов.					
16		2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49	XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.		Улсын бүртгэлийн байгууллага нь бүрэн цахимжиж, өдөр тутмын бүртгэлүүд “Үндэсний дата төв”-өөр дамжин бүртгэгдэж байна.	100		
<b>ЗГ-ын албан даалгавар</b>								
17	53	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах.	Монгол улсад 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн 16 насанд хүрсэн иргэн бүрт тоон гарын үсгийг олгож эхэлсэн. Уг ажлыг эрчимжүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, ХААН банкттай хамтран “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян”-ыг зохион байгуулж ажиллав. Энэ ажлын хүрээнд төмөр замын болон сургууль цэцэрлэгийн байгуулагуудад албан тоот хүргүүлж, 16-аас дээш насны иргэдэд тоон гарын үсгийг олгох, сургалт сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллав. Эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 16-аас дээш насны 11562 иргэнд тоон гарын үсэг олгохоос, нийт 5728 иргэнд тоон гарын үсгийг зохих журмын дагуу олгож, хамрагдалт 49.6%-тай байна.	100		
18	56	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай	1. 1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2."Алсын хараа-2050" Монгол		Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлаар аймгийн засаг дарга, харъяа байгууллагын дарга нар Баянтал, Шивээговь сумдад ажиллан 100 гаруй иргэд хүрч	100		



		<p>2022-07-05 Дугаар 2022_6</p>	<p>Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;</p>		<p>ажиллалаа.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдахад мэдээлэл зөрүүтэй өрхийн мэдээллийн зөрүүг арилгах зорилгоор Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Авто тээврийн төв нарын хамтарсан баг 2023 оны 01-р сарын 30-нд Сүмбэр суманд, 31-нд Шивээговь суманд “Нээлттэй Говьсүмбэр” өдөрлөгийг зохион байгуулж, иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 176 иргэний мэдээллийг шалгаж, хаягийн зөрчлийг арилгах талаар иргэдэд зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллав.</p> <p>Монголын Хуульчдын холбооны Говьсүмбэр аймаг дахь салбар, Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүрийн 5 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулдаг “ХУУЛЬЧИЙН ПРО БОНО” өдөрлөгт оролцож, 21 иргэнд тоон гарын үсэг олгож, улсын бүртгэлийн үйлчилгээний талаар мэдээлэл хүргэж ажиллалаа.</p> <p>“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”-ны тэргүүн Д.Цэндмаатай уулзаж, аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 11 иргэнд Улсын бүртгэлийн байгууллагын талаар мэдээлэл хүргэж, 7 иргэнд тоон гарын үсэг олгож, иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 1 иргэнийг</p>			
--	--	---	---	--	--	--	--	--

					<p>бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд 2023 оны 11-р сарын 06, 07, 08-ны өдөр Баянтал, Шивээговь, Сүмбэр сумдад “Танд хүрч үйлчилье” нээлттэй өдөрлөгийг бүрэн бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 48 бүртгэлийг бүртгэж, 125 иргэдэд зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллав.</p> <p>Тус хэлтсээс ажлын байран дээрээс иргэдэд мэдээлэл өгөхөөс гадна ХААН банкны салбарууд, Шивээговь ХК, ЕБС, Цэцэрлэгүүд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уул уурхайн политехникийн коллеж зэрэг 12 байгууллага, аймгийн ахмад настануудад сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан 800 гаруй иргэнийг хамруулсан.</p>			
--	--	--	--	--	--	--	--	--

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:  
БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ, НЯРАВ

В.ГЭРЭЛЧИМЭГ

ХЯНГАСАН:ДАРГА

З.БАЯНДУГАР